

2025 оны 03 сарын 14 өдөр

№ BR 25/ 007

Улаанбаатар

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дох хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон, “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 6.3-р зүйлийн 6.3.9, болон 6.3.13 дах хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минутаас “Тэнгэр Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк [www.facebook.com/tengerdaatgal](http://www.facebook.com/tengerdaatgal) хаягаар дамжуулан цахимаар хуралдуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг [www.investmentexpo.mn](http://www.investmentexpo.mn) вэбсайтаар хэрэгжүүлсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;
  - Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
  - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  - Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 04-ний өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2025 оны 03 сарын 29-ний өдөр болон 2025 оны 04 сарын 11-ний өдрүүдэд өдөр тутмын сонин, Компанийн [www.tengerdaatgal.mn](http://www.tengerdaatgal.mn) вэбсайт болон Монголын хөрөнгийн биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсаар 2025 оны 03 сарын 19-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2025 оны 04 сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минут хүртэл байна.
8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2025 оны 03 сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.
9. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 03 сарын 22-ны өдрийн дотор Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Шаравпэлжээ овогтой Гантуяаг томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах тогтоолын төслийг **Хавсралт №4**-өөр баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг **Хавсралт №5**-аар баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загварыг **Хавсралт №6**-аар баталсугай.
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Балдан овогтой Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш. ГАНТУЯА